



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар A/39

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг хүчингүй
 болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Шивээговь сумын 2 дугаар баг, Страто ХХК-ийн үйлдвэрийн хашаанаас Шоовойн говь хүртэлх 18.8 км, Авто зам барих зориулалтаар эзэмшиж авсан газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зориулалтын дагуу ашиглаагүй тул газар эзэмших эрхийг хүчингүй болгосугай.

2. Газар эзэмших эрх дуусгавар болгосныг Страто ХХК, болон захирал А.Баттүшигт мэдэгдэхийг сумын газрын даамал-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны A/137 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА